

Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтэс

ХҮН АМЫН АМЬДАРЧ БУЙ ОРЧИН НӨХЦӨЛ



Улаанбаатар хот
2016 он



НУТАГ ДЭВСГЭР, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ

Хан-Уул дүүрэг нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын баруун урд хэсэгт дархан цаазат Богд хан уулын ар хормой, Туул голын савд 48.5 мянган га нутаг дэвсгэрийг эзэлж оршдог. Тус дүүрэг нь 2015 оны байдлаар 16 хороо, 43.3 мянган өрхийн 150.9 мянган хүн амтай.

Хүснэгт 1. Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж

Хороо	Нутаг дэвсгэрийн хэмжээ, мян.км ²	Хүн амын нягтрал
1-р хороо	1.6	5696
2-р хороо	2.2	4795
3-р хороо	6.2	2247
4-р хороо	3.5	2705
5-р хороо	1.0	5975
6-р хороо	0.9	7231
7-р хороо	0.9	5132
8-р хороо	2.1	5365
9-р хороо	3.8	2430
10-р хороо	50.3	185
11-р хороо	152.3	96
12-р хороо	46.7	126
13-р хороо	133.9	30
14-р хороо	76.5	62
15-р хороо	1.1	18607
16-р хороо	1.7	6604
Дүн	484.7	311.4


Газрын нэгдмэл сан нь шинэчлэн найруулсан Монгол Улсын газрын тухай хуулийн 10-р зүйлд заасны дагуу үндсэн 6 санд хуваагдаж байна.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн газрын нэгдмэл сан нийт 48466 га байна.

Үүнээс: хөдөө аж ахуйн газар 22612.2 га буюу 46.7 хувь, хот тосгон бусад суурин газар 6927.1 га буюу 14.3 хувь, зам шугам сүлжээний газар 1074.7 га буюу 2.2 хувь, ойн сан бүхий газар 2098.0 га буюу 4.3 хувь, усан сан бүхий газар 975.0 га буюу 2.0 хувь, улсын тусгай хэрэгцээний газар 14779.0 га буюу 30.5 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 1. Газрын нэгдмэл сан¹

Эх үүсвэр: Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2015 оны кадастрын улсын бүртгэл



Нийт 48466 га газраас иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилсөн нийт 580.5 га, иргэний гэр хорооллын эзэмшилд нийт 695.5 га, төрийн байгууллагын эзэмшилд нийт 225.7 га, аж ахуйн нэгжийн эзэмшилд 1151.4 га, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн ашиглалтанд 25.7 га, хөдөө аж ахуйн эзэмшил, ашиглалтанд нийт 892.9 га, хот

тосгон бусад суурин газрын эзэмшил, ашиглалтанд нийт 2678.8 га тус тус байна.

ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ


Хан-Уул дүүргийн гэр хороололд амьдардаг өрх, хүн амын тоо 2008 оноос эхлэн нэмэгдэж, 2009 оны байдлаар нийт өрхийн 65.1 хувь, 2010 онд 60.3 хувь, 2011 онд 58.7 хувь, 2012 онд 57.0 хувь, 2013 онд 56.4 хувь, 2014 онд 51.9 хувь, 2015 онд 50.1 хувь нь гэр хороололд амьдарч байна.

Хүснэгт 1. Орон сууцны болон сууцны тусдаа байшин, гэрт амьдардаг өрхийн судалгаа

Үзүүлэлт	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	
Нийт өрхийн тоо	27808	30678	31517	33982	35349	39189	43280	
Үүнээс:	Орон сууцны хорооллын өрхийн тоо бүгд, үүнээс:	9710	12177	13027	14610	15425	18853	21612
	нийтийн орон сууцны	9435	11909	12751	14326	15064	18473	21035
	тусдаа тохилог орон сууц	221	262	275	284	358	380	571
	орон гэргүй	54	6	1	0	3	0	6
	Гэр хорооллын өрхийн тоо бүгд, үүнээс:	18098	18501	18490	19372	19924	20336	21668
	тохилог орон сууцанд	155	163	163	175	149	155	377
	байшинд амьдардаг	11664	11952	12145	12574	12587	12674	11664
	монгол гэрт амьдардаг	6128	6306	6155	6597	7150	7486	9613
	орон гэргүй	151	80	27	26	38	21	14
	Орон сууцны хороололд амьдарч буй өрхийн эзлэх хувь	34.9	39.7	41.3	42.9	43.6	48.1	49.9
Гэр хороололд амьдарч буй өрхийн эзлэх хувь	65.1	60.3	58.7	57.0	56.4	51.9	50.1	

Сүүлийн жилүүдэд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орон сууцны барилгууд ихээр нэмэгдэж, 2009 оноос орон сууцны хорооллын өрхийн тоо 11600 өрхөөр нэмэгдсэн хэдий ч нийслэл хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс шууд шалтгаалж гэр хорооллын өрх, хүн амын тоо буурахгүй байна.

Зураг 1. Дүүргийн өрх, хорооллоор




2015 оны байдлаар дүүргийн нийт өрхийн 50.1 хувь нь гэр хороололд, 49.9 хувь нь орон сууцны хороололд оршин сууж байна. Нийт орон сууцны хорооллын өрх 21035 болж, 2009 оноос 11600 өрхөөр, гэр хорооллын өрх 21668 болж 3570 өрхөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Дүүргийн өрх, хороогоор, 2015 оны эцэст

Хороо	Нийт өрх	Орон сууцны хороололд			Гэр хороололд			
		Нийтийн орон сууц	Тусдаа тохилог орон сууц	Орон гэргүй	Тусдаа тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Монгол гэр	Орон гэргүй
1-р хороо	2276	2273	3					
2-р хороо	2670	2605	9	6			50	
3-р хороо	3918	3847	17				54	
4-р хороо	2982	1051			22	1022	882	5
5-р хороо	1564					1222	342	
6-р хороо	1959				62	1220	675	2
7-р хороо	1411				13	799	599	
8-р хороо	3345					1636	1709	
9-р хороо	2465					1518	946	1
10-р хороо	2432	991	31			804	606	
11-р хороо	3910	2808	376		209	185	332	
12-р хороо	1806	246	1		2	1097	460	
13-р хороо	1447	108			57	575	706	1
14-р хороо	1666				12	516	1138	
15-р хороо	6052	5910	134			3	5	
16-р хороо	3377	1196				1067	1109	5
Нийт дүн	43280	21035	571	6	377	11664	9613	14

Зураг 2. Дүүргийн өрх, сууцны төрлөөр



Гэр хороололд суурьшсан өрхийн тоо 2009 оноос 3570 өрхөөр нэмэгдэж, 2015 оны эцэст 21668 өрх болов. Гэр хороололд суурьшсан 21668 өрхийн 44.4 хувь буюу 9613 нь монгол гэрт, 53.8 хувь буюу 11664 өрх байшин хороололд, 1.7 хувь буюу 377 нь тусдаа тохилог орон сууц, 0.06 хувь буюу 20 өрх орон гэргүй тус тус амьдарч байна.

Зураг 3. Орон сууц, гэр хорооллын өрх хүн ам, орон гэргүй өрх



2015 онд нийт өрхийн 0.04 хувь буюу 20 өрхийн 28 хүн орон гэргүйн улмаас урц овоохой, шатны хонгил зэрэг зориулалтын бус сууцанд амьдарч байна. Үүнээс орон гэргүй 14 өрхийн 20 хүн гэр хороололд байна.

Танилцуулга бичсэн: Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Н.Энэрэл
Э.Батзаяа